



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 1/512

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "л", Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2010 оны А-156 дугаар тушаалаар батлагдсан "Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал батлах тухай тушаалын 3 дугаар зүйл, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын"-ын 2 дугаар зүйлийн 2.1.4, 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын 1 дүгээр багийн нутаг "Хаяттай уул" нэртэй талбайд хууль бусаар жонш олборлосны улмаас эвдрэлд орсон газарт экологи эдийн засгийн үнэлгээ, нөхөн сэргээлтэд шаардлагатай зардлыг тооцох ажлыг хийж гүйцэтгэхэд 4.132.000 /дөрвөн сая нэг зуун гучин хоёр мянган/ төгрөгийн санхүүжилтийг "Ойт бүс" ХХК/байгаль орчны судалгаа, үнэлгээний мэргэжлийн/-д олгосугай.

2. Экологи эдийн засгийн үнэлгээ, нөхөн сэргээлтэд шаардлагатай зардлыг тооцох ажлын зардлын зарцуулалтыг хавсралтаар баталсугай.

3. Экологи эдийн засгийн үнэлгээ, нөхөн сэргээлтэд шаардлагатай зардлыг тооцох ажлыг Засаг даргын нөөц сангийн байгууллага, иргэдээс тавьсан хүсэлтийг шийдвэрлэх зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй.

4. Экологи эдийн засгийн үнэлгээ, нөхөн сэргээлтэд шаардлагатай зардлыг тооцох ажлын зардлыг буруутай этгээдээр төлүүлж, төсөвт төвлөрүүлэхийг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Б.Дарханбаатар/-д даалгасугай.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

11 Аймгийн Засаг даргын 2020 оны
дугаар сарын 11 өдрийн 11/5/2
дугаар захирамжийн хавсралт

Мөрөн сумын 1 дүгээр багийн нутаг "Хавтгай уул" гэх талбайд байгаль орчинд учруулсан хохирол тооцох ажлын зардал

№	Зардлын нэр	Хүний тоо	Нэгжийн үнэлгээ /төг/	Нийт дүн /төг/
1	Дроноор зураг авч программ дээр боловсруулах	1	500.000	500.000
2	Хөрсний хохирол тооцох	1	500.000	500.000
3	Газрын хохирол тооцох	1	500.000	500.000
4	Биологийн болон техникийн нөхөн сэргээлтийн зардал тооцох	1	500.000	500.000
5	Хөрсний шинжилгээ		100.000	100.000
6	Дүгнэлт бичих		500.000	500.000
7	Шатахуун		157.500	157.000
8	Бүгд			2.730.000
9	НӨАТ (10%)			275.700
	Нийтдүн			3.032.700

Мөрөн сумын 1 дүгээр багийн нутаг "Хавтгай уул" нэртэй газар эвдэрсэн талбайн хэмжээг гаргах, нөхөн сэргээлтийн зардал тооцох ажлын зардал

№	Зардлын нэр	Хүний тоо	Нэгжийн үнэлгээ /төг/	Нийт дүн /төг/
1	Дроноор зураг авч программ дээр боловсруулах талбайн хэмжээг гаргах	1	500.000	500.000
2	Биологийн болон техникийн нөхөн сэргээлтийн зардал тооцох	1	500.000	500.000
3	бүгд			1000.000
4	НӨАТ (10%)			100.000
	Нийтдүн			1.100.000